Сухай - холимог сөөгөн бүлгэмдэл, тусгагийн бүрхэц 20-25%, Олон цэцэгт Сухай – *Tamarix ramosissima* Ldb., Зүүн гарын Бударгана (улаан бударгана)- *Reaumuria soongorica* (Pall.) Maxim., Шар Хотир – *Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim., Харгана – *Caragana sp.*, Бор Бударгана – *Salsola passerine* Bge., Ахар навчит Баглуур – *Anabasis brevifolia* C.A.Mey., Сибирь Хармаг – *Nitraria sibirica* Pall. зэрэг 7 зүйл сөөг, сөөгөнцөр ургамалтай.

**Хайгуулын өрөмдлөгийн 4-р цэг:** нүүрсний уурхайн нүүрс овоолгийн хажууд ургамалан нөмрөг бүрэн устсан.



Зураг 69. нүүрс овоолгийн хажууд ургамалан нөмрөг бүрэн устсан байдал

**Хайгуулын өрөмдлөгийн 5-р цэг:** Нүүрсний уурхайн ашиглалтын талбайн захад. Аараг тологдын дундах элс, шавран хурдастай, хужир мараатай, хурын ус хуримтлагдаг гуу, жалга. Уурхан нөлөөлөлд автсан.



Зураг 70. Нүүрсний уурхайн ашиглалтын талбайн захад. Аараг тологдын дундах элс, шавран хурдастай, хужир мараатай, хурын ус хуримтлагдаг гуу, жалга. Уурхан нөлөөлөлд автсан байдал

Хармагт – дэрэст бүлгэмдэлтэй. Тусгагийн бүрхэц 20%. Зүүн гарын Бударгана (улаан бударгана)- *Reaumuria soongorica* (Pall.) Maxim., Шар Хотир – *Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim., Сибирь Хармаг – *Nitraria sibirica* Pall, Дэрс (гялгар дэрс, цагаан дэрс) - *Achnatherum splendens* (Trin.) Nevski. зэрэг сөөг, сөөгөнцөр ургамалтай.

**Хайгуулын суурин орчмын ургамалжилт:** Уулын энгэрийн бага зэрэг хэвгий тэгш, чулуурхаг газар бөгөөд хурын усанд эдэгдсэн гуу, жалгуудаар хэрчигдсэн ландшафттай. Иймд уулын хаяа, бэлийн болон гуу жалганы ургамлын хэв шинжтэй бүлгэмдэл илэрнэ.

Чулуурхаг тэгш талаар гүйлс – харгана – баглуурт бүлгэмдэл. Тусгаг 10-15%, Монгол Бүйлс - *Amygdalus mongolica* (Maxim.) Ricker., Харгана – *Caragana* sp., Өргөст Ортууз – *Oxytropis*

*aciphylla* Ldb., Шар Хотир – *Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim., Харгана – *Caragana* sp., Бор Бударгана – *Salsola passerine* Bge., Ахар навчит Баглуур – *Anabasis brevifolia* C.A.Mey. зэрэг ургамалтай.



Зураг 71. Хайгуулын кемпийн ойр орчмын газрын ургамажилт

#### **Төслийн талбайн зүйлийн бүрэлдэхүүн**

Бид судалгааг 2022 оны 4-р сарын дунд үед хийгдсэн тул ургамал ургалтын хугцаа хараахан бүрэн ургаж ихлээгүй байсан тул цөөн тооны ургамлуудын зүйлийг жагсаасан болно.

Өмнөговь аймаг Гурвантэс, Ноён сумын нутгуудыг хамруулан “Тост Элс” ХХК-ийн хийсэн байгаль орчны төлөв байдлын судалгаагаар 30 овог, 78 төрөлд хамаарах нийт 106 зүйл ургамал тэмдэглэгдсэн. Хамгийн олон зүйлтэй нь Гагадайн овог 12 төрлийн 18 зүйл ургамал, удаад нь нийлмэл цэцэгтний овог 9 төрлийн 18 зүйл, түүнчлэн буурцагтны 8 төрлийн 11 зүйлтэйгээр тус тус зонхилно. Нийт зүйлийн бүрдлийн дотор жижиг мод 2 зүйл, сөөг 8 зүйл, 7 зүйл сөөгөнцөр, 10 зүйл заримдаг сөөгөнцөр, 51 зүйл олон наст өвс, 7 зүйл хоёр наст, 21 зүйл нэг наст ургамал тус тус тэмдэглэсэн байна.

Ургамлын судалгаагаар 6 овогын 9 төрөлд хамаарах 9 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ховор 2 зүйл, завсарын унаган 1 зүйл, үлдвэр 3 зүйл ургамал бүртгэгдлээ.

Хүснэгт 31. Хайгуулын болон кемпийн ойролцоох ургамлын зүйлийн жагсаалт

Овог	Дугаар		Ургамлын зүйлийн нэр	Статус	Экологийн бүлэг	Амьдралын хэлбэр	АА-н ач холбогдол
	Төрөл	Зүйл					
<b>Үетний овог - Poaceae Barnhart.</b>							
1	1	1	Дэрс (гялгар дэрс, цагаан дэрс) - <i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski.	Элбэг	Чийгсүү-Хуурайсаг	Олон наст өвс	Бэлчээр
<b>Гагадайн овог - Amaranthaceae Juss.</b>							
2	2	2	Ахар навчит Баглуур – <i>Apabasis brevifolia</i> C.A.Mey.	Элбэг	Хуурайсаг	Заримдаг сөөгөнцөр	Бэлчээр
	3	3	Бор Бударгана – <i>S. passerine</i> Bge.	Элбэг, субэнд емик	Хуурайсаг	Заримдаг сөөгөнцөр	Бэлчээр
<b>Хармагийн овог – Nitrariaceae Lindl.</b>							
3	4	4	Сибирь Хармаг – <i>Nitraria sibirica</i> Pall.	Элбэг	Хуурайсаг, Элссэг	Сөөг	Эм, бэлчээр, хүнс, элс тогтоогч
<b>Сухайн овог- Tamaricaceae Link.</b>							
4	5	5	Зүүн гарын Бударгана (улаан бударгана)- <i>Reaumuria soongorica</i> (Pall.) Maxim.	Элбэг, үлдвэр	Хуурайсаг Давссаг	Заримдаг сөөгөнцөөр	Бэлчээр
	6	6	Олон цэцэгт Сухай – <i>Tamarix ramosissima</i> Ldb.	Ховор, үлдвэр	Хуурайсаг	Мод	Эм, бэлчээр
<b>Хотирын овог – Zygophyllaceae R.Br.</b>							
5	7	7	Шар Хотир – <i>Zygophyllum xanthoxylon</i> (Bge.) Maxim.	Элбэг, үлдвэр	Хуурайсаг	Сөөг	Эм, бэлчээр
<b>Буурцагтны овог - Fabaceae Lindl.</b>							
6	8	8	Харгана - <i>Caragana</i> sp.				
	9	9	Өргөст Ортууз – <i>Oxytropis aciphylla</i> Ldb.	Ховор	Хуурайсаг	Олон наст өвс	Эм, бэлчээр



## ТАВ. Амьтны аймгийн судалгаа

Амьтны аймгийн хээрийн судалгаанд замналын дагуу тааралдсан амьтдыг бүртгэх, тодорхой амьдрах орчны өвөрмөц онцлог бүхий газруудад суурин ажиглалтын талбайг сонгон тааралдсан бүх биологийн төрөл зүйлийг бүртгэн тэмдэглэсэн.

Хээрийн судалгаанд нийт 200 км орчим маршрутын дагуу судалгааг гүйцэтгэж, амьтны ажиглалт 3 удаа явуулж дээрх замналд нийт 52 хар сүүлт (*Procapra gutturosa*) зээрийг биеэр болон ул мөрөөр, үүнээс 8 бодгалийг биеэр харж, 1 сэг зэм, 15 ул мөр бүртгэсэн байна. Мөн нэг боролзон туулай тэмдэглэсэн. 3 багийн 5 овогт хамаарах 8 зүйлийн шувууд, цоохор хонин гүрвэл (*Eremias argus*) 1 бодгаль. Түүнчлэн сохор элээ (*Milvus migrans*) шувууны үүрний байршил болон бусад амьтны ул мөр зэргийг тэмдэглэн зургийг авч баримтжуулав.

### Арга зүй

Зурвас замлалын судалгаа: Автомашинаар, явсан газрын байдалд тохируулан тодорхой зурвас амьтныг тоолж бүртгэнэ. Уулын туруутан, тал хээрийн амьтныг судлахад энэ аргыг өргөн хэрэглэдэг. Байр зүйн зураг дээр явж судалсан зурвасын хэмжээ буюу хамарсан нутгийн урт өргөн нь тодорхой байх шаардлагатай.

- Зурвас замлалын аргаар цуглуулсан мэдээ, хэрэглэхүүнийг нэгтгэн тооцох нь:
- Шулуун замлалын урт: L<sub>1</sub>–одометрийн, эсвэл GPS-ийн заалт
- Шулуун замлал дахь амьтан хүртэлх дундаж зай.

$$W_1 = \frac{W_1 + W_2 + W_n}{n} ;$$

- W<sub>1</sub>–тухайн замлалд тэмдэглэсэн амьтан хүртэлх дундаж өргөн
- W<sub>1,2...n</sub>–тухайн замлалын чиглэлээс амьтан хүртэлх перпендикуляр зай
- n-нийг тэмдэглэсэн сүргийн тоо.
- Дундаж өргөнийг гаргахад 500 м хүртэл, 501-1000 м, 1001-1500 м гэх мэт интервал хэрэглэнэ.

Замлалд харгалзах талбай:

- S<sub>1</sub>=L\* W<sub>a</sub>;
- S<sub>1</sub>–замлалд харгалзах талбай,
- L–замлалын урт,

- $W_a$ –замлалын дундаж өргөн
- $N_d$ –дээж талбайд тоолсон нийт амьтан.
- Тухайн ажигласан талбайд байгаа амьтны нягтшилыг  $10 \text{ км}^2$ -д (1000 га) ногдох толгойн тоогоор гаргана.

Тархац (дэлхэц) нутаг дахь амьтны тоо:

$$N_t = \frac{N_s N_d}{S_1} \quad \text{буюу} \quad N_t = \frac{N_s N_d}{L W_a}$$

- $N_s$ –тархац нутгийн талбайг нутгийн иргэн, мэргэжилтэн, судалгааны бүтээл, эх сурвалжийн мэдээг үндэслэн газрын зураг дээр тэмдэглэж ArcGIS программ ашиглан тогтооно.
- $N_t$ –тархац нутаг дахь амьтны нөөц

Цэгэн ажиглалтын судалгаа. Товолсон тодорхой талбайд тодорхой хугацаанд сууж үзэгдсэн амьтныг бүртгэх арга юм. Энэ арга нь амьтны усанд ирэх, идэшлэх газартаа бэлчээрлэх зэрэг үйл хөдөлгөөн нь идэвхижсэн үед голдуу хэрэглэдэг.

#### **Гурвантэс сумын амьтны аймгийн тухай товч танилцуулга**

Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт хамаарах “Гурвантэс XXXV” төслийн талбай нь амьтны газарзүйн мужлалын хувьд Говь-Алтайн болон Алтайн өвөр говийн тойрогт хамаарах (А.Г.Банников 1954) говь цөлийн амьтад тэргүүлэх бөгөөд мэрэгчдээс чичүүл, сохор оготно, савагдаахай, загийн шар чичүүл, говийн алаг даага, бор зусаг, туурайтнаас хар сүүлтий, хулан, янгир, аргаль, араатнаас үнэг зонхилно. Зөвхөн энэ тойрогт нийтлэг бөгөөд бусад нутагт үзэгддэггүй буюу ховор үзэгддэг амьтад цөөнгүй байна. Тэдгээрийн тоонд цагаан цээжит малтаахай, сармаахай, мазаалай, цоохондой, хавтгай, төвд туулай, соотон алагдаага, козловын сарвуудай орно. Түүнчлэн ирвэс, шилүүс, хадны суусар гэх мэт уулын амьтад хад чулуун дунд үзэгдэнэ.

#### **Амьтны аймгийн судлагдсан тойм**

##### **Хөхтөн амьтад**

Төслийн талбай, түүний орчмын бүс нутагт хөхтөн амьтнаас шавж идэштэн 2, гар далавчтан 2, туулай хэлбэртэн 1, мэрэгчтэн 16, махчтан 8, туурайтан 1, туруутан 3 зүйл, нийт 7 багийн 33 зүйл хөхтөн амьтан тохиолдох боломжтой.

Хүснэгт 32. Хөхтөн амьтны бүрэлдэхүүн

Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	IUCN Red List (2006) Global category	Монгол Улсын ховор амьтны жагсаалт, 2001	Монгол улсын улаан ном, 1987,1997	CITES I, II хавсралт	Улаан данс (2006)	Амьтны аймгийн тухай хууль	Ан агнуурын тухай хууль
<b>АЦ ТУРУУТНЫ БАГ-ARTIODACTYLA</b>								
Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	ЭМ	+	+	II	УБ	ХО	ХО
Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	АӨ	+	+	-	ХБ	ХО	ХО
Хар сүүлтэй	<i>Gazella subgutturosa</i>	ЭМ	+	+	-	ЭМ	ХО	ХО
<b>ТУУРАЙТНЫ БАГ-PERISSODACTYLA</b>								
Хулан адуу	<i>Equus hemionus</i>	ЭМ	+	+	II	УБ	ХО	ХО
<b>МАХ ИДЭШТНИЙ БАГ-CARNIVORA</b>								
Шилүүс мий	<i>Lynx lynx</i>	ХБ	+	-	II	ХБ	ХО	АЗ
Мануул мий	<i>Otocolobus manul</i>	ХБ	-	-	II	ХБ	-	АЗ
Саарал чоно	<i>Canis lupus</i>	АӨ	-	-	II	ХБ	-	АЗ
Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	АӨ	-	-	-	ХБ	-	АЗ
Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	АӨ	-	-	-	ХБ	-	АЗ
Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>	АӨ	+	+	-	МД	ХО	ХО
Цоохондой мий	<i>Felis lybica</i>	АӨ	+	+	II	МД	ХО	ХО
Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i>	УБ	+	+	I	УБ	НХ	НХ
<b>ТУУЛАЙТНЫ БАГ-LAGOMORPHA</b>								
Боролзон туулай	<i>Lepus tolai</i>	АӨ	-	-	-	АӨ	-	АЗ
<b>МЭРЭГЧДИЙН БАГ-RODENTIA</b>								
Бозлог зурам	<i>Citellus pallidicauda</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Бордуу шишүүхэй	<i>Cricetulus migratorius</i>	ХБ	-	-	-	МД	-	-
Орог зусар	<i>Phodopus campbelli</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Элсний зусар	<i>Phodopus roborovskii</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Шаргал чичүүл	<i>Merionus meridianus</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Морин чичүүл	<i>Rhombomys opimus</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Говийн алагдаага	<i>Allactaga bullata</i>	ХБ	-	-	-	МД	-	-
Сибирь алагдаага	<i>Allactaga sibirica</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Таван-хуруут атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>	ЭМ	-	+	-	МД	-	-
Савагдаахай	<i>Dipus sagitta</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Соотон алагдаага	<i>Euchoreutes naso</i>	УБ	-	+	-	ЭМ	-	-
Зэгэл алагдааганцар	<i>Pygerethmus pumilio</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Өөхөн-сүүлт атигдаахай	<i>Salpingotus crassicauda</i>	ЭМ	-	+	-	МД	-	-
Козловын атигдаахай	<i>Salpingotus kozlovi</i>	ХБ	-	+	-	МД	-	-
Монгол даахай	<i>Stylodipus andrewsi</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
<b>ГАР ДАЛАВЧТАНЫ БАГ-CHIROPTERA</b>								
Бор гурсаахай	<i>Hypsugo alaschanicus</i>							
Саарал соотон багваахай	<i>Plecotus kozlovi</i>							
<b>ШАВЖ ИДЭШТНИЙ БАГ-INSECTIVORA</b>								
Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>	АӨ	-	-	-	АӨ	-	-
Сибирь малтаахай	<i>Crocidura sibirica</i>	АӨ	-	-	-	МД	-	-

Тайлбар: АӨ-анхааралд өртөхөөргүй, МД-мэдээлэл дутмаг, УБ-устааж болзошгүй, ХБ-ховордож болзошгүй, ЭМ-эмээг, ХО-ховор, НХ-нэн ховор, АЗ-ангийн зөвшөөрөл олгодог.

## Мөлхөгчид

Судлаачдын бүтээлд энэ бүс нутагт нэлээд хэдэн зүйл мөлхөгч амьтан тэмдэглэсэн боловч тэдгээрээс зөвхөн 7 зүйл гүрвэл, 5 зүйл могой тохиолдоно.

### Хүснэгт 33. Мөлхөгчдийн бүрэлдэхүүн, хамгаалсан байдал

№	Зүйлийн нэр	Хамгаалсан байдал	
		Бүс нутгийн шалгуур, үнэлгээ	Олон улсын үнэлгээ
<b>Гүрвэлийн салбар баг-Sauria</b>			
1	Төмөр гүрвэл- <i>Alsophylax pipiens</i>	АӨ	ҮХ
2	Нохой гүрвэл- <i>Teratoscincus przewalskii</i>	ХБ	ҮХ
3	Замба гүрвэл- <i>Laudakia stoliczkana</i>	ХБ	ҮХ
4	Цоохор хонин гүрвэл- <i>Phrynocephalus versicolor</i>	АӨ	ҮХ
5	Говийн гүрвэл- <i>Eremias przewalskii</i>	АӨ	ҮХ
6	Могой гүрвэл- <i>Eremias multiocellata</i>	АӨ	ҮХ
7	Загалт гүрвэл- <i>Eremias vermiculata</i>	АӨ	ҮХ
<b>Могойн салбар баг-Serpentes</b>			
1	Тэмээн сүүл могой- <i>Eryx tataricus</i>	ХБ	ҮХ
2	Нарийн могой- <i>Coluber spinalis</i>	ХБ	ҮХ
3	Рашааны могой- <i>Elaphe dione</i>	АӨ	ҮХ
4	Сум могой- <i>Psammophis lineolatus</i>	АӨ	ҮХ
5	Бамбай хоншоорт могой- <i>Aqkistrodon halys</i>	АӨ	ҮХ

**Тайлбар:** ХБ-ховордож болзошгүй, ҮХ-үнэлгээ хийгдээгүй, АӨ-анхааралд өртөхөөргүй,

## Шувууд

Шувууны бүрэлдэхүүнийг гаргахдаа тус нутгаар дайрч өнгөрдөг нүүдлийн шувуудыг оруулалгүй зөвхөн тус нутагт ирж өндөглөн зусдаг болон суурин шувууд, урьд хийсэн судалгаа болон өөрсдийн хээрийн судалгаагаар илрүүлсэн нийт 9 багийн 39 зүйл шувуу бүртгэлээ.

### Хүснэгт 34. Шувууны бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр

№	Зүйлийн нэр	Оршин амьдрах хэлбэр		
		Суурин	Тохиолдлын	Нүүдлийн
<b>Галуутан-Anseriformes</b>				
1	Хондон ангир- <i>Tadorna ferruginea</i>			+
2	Бор нугас- <i>Anas strepera</i>			+
<b>Шонхортон-Falconiformes</b>				

№	Зүйлийн нэр	Оршин амьдрах хэлбэр		
		Суурин	Тохиолдлын	Нүүдлийн
3	Сохор элээ- <i>Milvus migrans</i>			+
4	Шилийн сар- <i>Buteo hemilasius</i>	+		
5	Тарважи бүргэд- <i>Aquila hipalensis</i>	+		
6	Идлэг шонхор- <i>Falco cherrug</i>	+		
7	Начин шонхор- <i>Falco tinnunculus</i>	+		
8	Зээрд шонхор- <i>Falco naumanni</i>			+
9	Нөмрөг тас- <i>Aegypius monachus</i>	+		
<b>Тогоруутан-Gruiformes</b>				
10	Өвөгт тогоруу- <i>Anthropoides virgo</i>			+
<b>Хиазтан-Charadriiformes</b>				
11	Нарийн хиазат- <i>Charadrius dubius</i>			+
12	Хүрэнтолгойт цахлай- <i>Larus ridibundus</i>			+
<b>Тагтаатан-Columbiformes</b>				
13	Хөхвөр тагтаа- <i>Columbia livia</i>	+		
14	Говийн ногтруу- <i>Syrhaptes paradoxus</i>	+		
15	Буулгат хүүрзгэнэ- <i>Streptopelia decaocta</i>		+	
<b>Ураацайтан-Apodiformes</b>				
16	Хондлой цагаан ураацай- <i>Apus pacificus</i>			+
<b>Өвөөлжтөн-Urupiformes</b>				
17	Бөвөөлжин өвөөлж- <i>Urupa erops</i>			+
<b>Уультан-Strigiformes</b>				
18	Хотны бүгээхэй- <i>Athene noctua</i>	+		
<b>Боршувуутан-Passeriformes</b>				
19	Боролзой божирго- <i>Alauda arvensis</i>			+
20	Цөлийн зэржигэнэ- <i>Silvia nana</i>			+
21	Дэрсний жиргэмэл- <i>Calandrella cheleensis</i>			+
22	Шоорон эвэртболжмор- <i>Eremophila aplestris</i>	+		
23	Хээрийн шийхнүүхэй- <i>Anthus richardi</i>			+
24	Хөх цэгцгий- <i>Motacilla alba</i>			+
25	Хулан жороо- <i>Podoces hendersoni</i>			+
26	Алаг шаазгай- <i>Pica pica</i>	+		
27	Хар хэрээ- <i>Corvus corone</i>	+		
28	Хон хэрээ- <i>Corvus corax</i>	+		
29	Эвэрт болжмор- <i>Galerida cristata</i>			+
30	Адууч чогчиго- <i>Oenanthe oenanthe</i>			+
31	Цөлийн чогчиго- <i>Oenanthe deserti</i>			+
32	Бүжимч чогчиго- <i>Oenanthe isabellina</i>			+
33	Науманы хөөндэй- <i>Turdus naumanni</i>			+
34	Хээрийн бор шувуу- <i>Passer montanus</i>	+		
35	Загийн бор шувуу- <i>Passer ammondendri</i>	+		
36	Оронгийн бор шувуу- <i>Passer domesticus</i>	+		
37	Хадны бор шувуу- <i>Petronia petronia</i>	+		
38	Алаг хөмрөг- <i>Emberiza hortulanaa</i>			+
39	Борлог хөмрөг- <i>Emberiza pusilla</i>			+
Бүгд: 39 зүйл		16	1	22

Шувуудаас 16 зүйл суурин амьдралтай, 22 зүйл нүүдэллэн ирж өндөглөн зусдаг, 1 зүйл тохиолдлоор бүртгэгдсэн байна.

### Амьтдын хамгаалагдсан байдал

Монгол улсын Улаан номонд орсон 6 зүйл, Засгийн газрын 164-р тогтоолд орсон 5, Ховор амьтан, ургамлыг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын (CITES) хавсралтанд орсон 9, Улаан дансанд (IUCN Red list of Threatened species) орсон 3 зүйл зэрэг хууль эрх зүйн баримт бичгээр хамгаалагдсан амьтан төслийн талбай болон түүний ойр орчимд тохиолдоно.

#### Хүснэгт 35. Төслийн талбай орчим дахь амьтдыг хамгаалсан байдал

Зүйлийн нэр	Ховордсоны баталгаа			
	Монгол улсын улаан ном	Засгийн газрын 164-р тогтоол	CITES	IUCN Улаан жагсаалт
Сохор элээ- <i>Milvus migrans</i>			+	
Шилийн сар- <i>Buteo hemilasius</i>			+	
Нөмрөг тас- <i>Aegyptus monachus</i>			+	
Идлэг шонхор- <i>Falco cherrug</i>			+	
Начин шонхор- <i>Falco tinnunculus</i>			+	
Зээрд шонхор- <i>Falco naumanni</i>			+	
Өвөгт тогоруу- <i>Anthropoides virgo</i>			+	
Хотны бүгээхэй- <i>Athene noctua</i>			+	
Хулан жороо- <i>Podoces hendersoni</i>	+			
Атигдаахай- <i>Cardiocranius paradoxus</i>	+			
Гувруу тажигдаахай- <i>Salpingotus crassicauda</i>	+			
Соотон алагдай- <i>Euchoreutes naso</i>	+			
Шилүүс- <i>Felis lynx</i>		+		
Цоохондой- <i>Felis silvestris</i>		+		
Эрээн хүрнэ- <i>Vormela peregusna</i>		+		Vulnerable A2c
Хулан адуу- <i>Equus hemionus</i>	+	+	+	Endangered A2abc+3bd
Хар сүүлтий- <i>Gazella subgutturosa</i>	+	+		Vulnerable A2ad
<b>Нийт: 17 зүйл</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>3</b>



## **Хөхтөн амьтдын амьдрах орчин**

**Аргаль хонь:** Монгол орны уулархаг нутгийн хад асгат налуу, тагийн бүсийн дэвсэгт байршин амьдарна.

**Янгир ямаа:** Өндөр уулсын цавчим хадтай газарт байршин амьдрах боловч улирлаар бэлчээрээ сэлгэж байрлана.

**Хар сүүлт:** Монгол орны цөлөрхөг хээр, цөлийн бутлаг, өвслөг ургамал бүхий аараг толгод, дэнж, хөндий дагаж байршина.

**Хулан адуу:** Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн өдлөг хялгана-хөмүүл, баглуур-бударганат бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга, талбиу дэнжээр бэлчээрлэнэ. Задгай булаг, шанд, тойром шүтэх авч, задгай усгүй нутагт сайранд татаал гаргаж ундаална. Ус, бэлчээр дагаж, байнга шилжиж хөдөлдөг.

**Шилүүс мий:** Шилүүс умард Монголд тайга, холимог ой, ойт хээр, хээрийн хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь, цөлийн хадат уулсаар тохиолдоно.

**Мануул мий:** Мануул ойт хээр, бүх хэв шинжийн хээр, хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь, цөлийн хадат уулсаар тохиолдоно. Хуурай, гандуу, задгай нутагт байршимтгай.

**Саарал чоно:** Саарал чоно туурайтан малын бэлчээрийг дагаж улирлаар байршлаа сэлгэнэ. Гэвч ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодоц сайтай хад асга бүхий өндөр уул, гүн ой тайгад байршин амьдарна. Ялангуяа бэлтрэглэх үедээ хүнээс алс зайдуу, усанд ойр, харууцтай газрыг сонгодог онцлогтой.

**Шар үнэг:** Монгол орны хойт хэсгийн ойт хээр, уулын тайга, өмнөд хэсгийн говь цөл, хээр, баруун хэсгийн өндөр уулын тайгын бүс зэрэгт хааяагүй тохиолдоно. Хярсг бодвол илүү чийглэг газраар тохиолдоно.

**Хярс үнэг:** Хээр болон цөлөрхөг хээрт байршин амьтдарна.

**Эрээн хүрнэ:** Хуурай хээр, заримдаг цөл, цөлийн бүсээр чичүүл элбэгтэй газар бараадан амьдарна. Хуурай хээрт намхан уулсын энгэр бэл, дэрстэй хөндий, говьд заг, бударганатай аараг толгод, хармагийн дов сондуул бүхий чийглэг газар бараадна.

**Цоохондой мий:** Цоохондой цөлийн баянбүрд, сухайн сондуулт бөөрөг, загт хотос, хад чулуут бэсрэг уулс, аараг толгод, сөөгт чулуут цөл, хайлааст сайр зэрэг говь, цөлийн гандуу нутагт тохиолдоно.

**Цоохор ирвэс:** Ирвэс 2500-3500м өндөр уулсын гүн хавцал жалга, хад цохиот эгц хажуу зэрэг гөрөөл амьтан отох, гэтэж ойртох, довтлох боломжтой бартаат газрыг илүү шүтэж байршина. Мөн говь, цөлийн хад чулуут уулс, баянбүрд шүтэж амьдарна.

**Боролзон туулай:** Боролзон туулай ойт болон уулын хээр, өндөр уулс, цөлөрхөг хээр, голын хөндий, нуур, тойрмын дэрст хөвөө, элсэн довцог, сайр, жалга, голын шугуй зэрэг газрын сөөг, бут, хад чулуутай, далдац сайтай нутагт тохиолдоно.

**Бозлог зурам:** Бозлог зурам Монгол орны говийн бүсийн хялганат, хааяа үетэн шавагт цөлөрхөг хээрт тохиолдоно.

**Хадны барагчин:** Ойт хээр, хээрийн дунд болон намхан уулсын хад асгатай хэсгээр байршина. Уулсаа дагаж говь цөлийн бүс рүү ч нэвтэрнэ.

**Бордуу шилүүхэй:** Баян бүрдүүд болон бутлаг ургамалжилт бүхий говь цөлийн нам уулс, тэдгээрийн хөндий орчмын нутагт байршин амьдарна.

**Орог зусаг:** Хээр болон говийн бүсэд булаг шанд, горхийн ойролцоо тохиолдох бөгөөд ялангуяа хээрт элбэг тохиолдоно.

**Элсний зусаг:** Элсэрхэг хөрстэй цөл, заримдаг цөлд байршин амьдардаг жинхэнэ элсээг амьтан.

**Шаргал чичүүл:** Жинхэнэ говийн амьтан. Элсэрхэг хөрстэй ухаа толгод, хотгор, хөндий, тэгш газар бараадна. Зарим тохиолдолд хагалсан газар ч амьдарна.

**Морин чичүүл:** Загтай элсэн довцог, хөндийгөөр их, бага колони (суурьшил) үүсгэн амьдарна.

**Говийн алгадаага:** Бударгана бүхий хайрган хөрстэй говь цөлд байршин амьдарна.

**Сибирь алгадаага:** Хээр, ойт хээр, хуурай хээрт голдуу байршин амьдарна. Өндөр уулын хээрээс заримдаг цөлд хүртэлх уудам орон зайд байршин.

**Таван-хуруут атигдаахай:** Сийрэг, тачир ургамалтай элсэн довцог, сул элсэн хөрстэй газарт байршин амьдарна.

**Савагдаахай:** Элсэн хөрстэй говь, цөл, цөлөрхөг хээрт голдуу байршин амьдарна.

**Соотон алгадаага:** Хайрган хөрстэй, сийрэг ургамалтай, хуурай цөлд байршин амьдарна.

**Зэгэл алагдааганцар:** Сийрэг ургамалжилт бүхий наанги хөрстэй, гандуу цөлд байршин амьдарна.

**Өөхөн-сүүлт атигдаахай:** Цөл болон заримдаг цөлийн шаварлаг, наанги хөрстэй нутагт байршин амьдарна.

**Козловын атигдаахай:** Элсэрхэг хөрстэй, заримдаг цөл, цөлд байршин амьдарна.

**Монгол даахай:** Элсэрхэг хөрстэй, сийрэг ургамалжилттай заримдаг цөлд байршин амьдарна.

**Бор турсаахай:** Бор турсаахай цөлийн баянбүрд, шал тойром, цөлөрхөг хээрийн булаг шанд, нуур тойром, хад чулуут бэсрэг уулс орчмын модлог ургамал болон хад чулуут газрыг шүтэж амьдарна. Хад, модны хонгил, агуй, чулуун болон тоосгон барилгын хана, дээвэр, туурь, бетон гүүр, малын хашаа, хороо зэрэгт орогноно.

**Саарал соотон багваахай:** Саарал соотон багваахай гандуу цөлийн баянбүрд, цөлөрхөг хээрийн нуур тойром, голын хөндий, булаг шанд орчим модлог ургамал болон хад чулуут газрыг шүтэж байршина. Хад, модны хонгил, агуй, байшин зэрэгт орогноно.

**Дэлдэн зараа:** Хуурай хээр, цөл, заримдаг цөлийн бутлаг ургамал бүхий хөндий, элсэн довцог, баян бүрдүүд, голын хуурайдуу сав газар зэрэгт байршин амьдарна.

**Сибирь малтаахай:** Холимог ой, хээр, цөл, цөлжүү хээр зэрэг олон янзын амьдрах орчинд тохиолдоно. Монгол орны нуур болон голын ойролцоох өтгөн ургамалтай чийглэг газруудад амьдарна.

**Мөлхөгч амьтдын амьдрах орчин**

**Төмөр гүрвэл** цав толгодын бэлээр хад чулуутай хайрга, шаварлаг эрэг, ганга, сийрэг бут сөөгтэй газар амьдарна. Өдрийн цагт чулуун дор хоргодож шөнө идэвхижинэ.

**Нохой гүрвэл** манхан, молцог элс, заган ойтой газраар голчлон амьдарна. Шөнийн амьдралтай.

**Замба гүрвэл** уулсын хад асга, сөөг ургамалтай газар, гол усны ойр орчим, баянбүрдэр амьдарна.

**Цоохор хонин гүрвэл** монгол оронд өргөн тархсан тоо толгойн нягтшил их, элбэг тохиолддог зүйл. Харгана, бударгана сийрэг ургасан таана, хөмүүлт цөлийн хээр, сайр садарга, хайрга чулуут, заг, хармагт элсэрхэг нутаг зэрэг олон янзын биотопд амьдарна.

**Говийн гүрвэл** түгээмэл тархалттай, элбэг тохиолддог зүйл. Хармаг, нохой шээрэнгэ, харгана, бударгана ургасан дов элс, молцог элс, дэл элс, манхан элс, элсэн тарамцагтай нутагт амьдарна.

**Могой гүрвэл** сөөглөг ургамалтай, хатуу хайрган хөрстэй, хад чулуутай, сөөг ургамалд хурж тогтсон элсэн тарамцаг бүхий нутагт голчлон амьдарна.

**Загалт гүрвэл** сөөг бүхий элсэрхэг нутагт амьдарна.

**Тэмээн сүүл могой** жинхэнэ цөлийн амьтан. Заг бүхий элсэн цөл, ногооны талбай, сууц, амбаарт тохиолдоно. Амьд зулзага төрүүлдэг, хоргүй могой. Монгол улсын 2 удаагийн улаан номонд ховор гэдэг статустайгаар хамгаалалтанд орсон хязгаарлагдмал тархацтай зүйл.

**Нарийн могой** уулсын хад чулуу, бутанд орогнон амьдарна. Хоргүй могой. Ховор амьтан тул Монгол улсын улаан номонд оруулж хамгаалсан.

**Рашааны могой** өргөн тархалттай, элбэг тохиолддог зүйл. Амьдрах орчны янз бүрийн нөхцөлд, гол төлөв усны ойролцоо тохиолдоно. Хоргүй.

**Сум могой** өргөн тархалттай боловч ховор тохиолддог зүйл. Уулын хад асга, бутлаг ургамал бүхий сайр садарга, хайргат болон элсэн цөл говийн баянбүрдэд тохиолдоно. Хүнд хор хөнөөлгүй.

**Бамбай хоншоорт могой** манай орны бүх нутагт тархсан, элбэг тохиолддог зүйл. Хад асга, хайрга бутат цөл, тал хээр, говь, нуга намаг зэрэг янз бүрийн орчинд амьдарна. Хортой тул болгоомжлох хэрэгтэй.

### **Шувуудын амьдрах орчин**

Нутгийн шувуудаас боршувуутаны багийнхан бусад багийнхаас тоо толгой олон тохиолдоно. Энэ багийн шувууд булаг дамнасан баянбүрдийг дагаж амьдарч байна. Ус намгийн амьдралтай 3 зүйл болон өвөөлж, сохор элээ, согсоот божирго, хээрийн бор шувуу мөн булаг, усны савд байршин зусна. Махчин шувууд устай амыг даган толгодоор байрших ба синантроп шувууд өвөлжөө, айлын ойролцоо тохиолдоно. Шувуудыг амьдрах орчны онцлогоор ангилж үзвэл:

- Ус намгийн: *Tadorna ferruginea*, *Anas strepera*, *Motacilla alba*;
- Мод бутны: *Milvus migrans*, *Athene noctua*, *Apus pacificus*, *Silvia nana*, *Pica pica*, *Corvus corone*, *Corvus corax*, *Turdus naumanni*, *Emberiza pusilla*;
- Хээр талын: *Buteo hemilasius*, *Aquila nipalensis*, *Falco tinnunculus*, *Calandrella heleensis*, *Eremophila alpestris*, *Alauda arvensis*, *Anthus richardi*, *Oenanthe oenanthe*, *Oenanthe deserti*, *Oenanthe usabellina*;
- Хад асганы: *Aegyphus monachus*, *Petronia petronia*, *Upupa epops*;
- Говь цөлийн: *Podoces hendersoni*, *Syrnhaptis paradoxus*, *Galerida cristata*, *Passer ammodendri*;
- Барилга байгууламжийн: *Columbia livia*, *Passer montanus*, *Passer domesticus* зэрэг шувууд байна.

Эдгээрээс хээр талын (10 зүйл), мод бутны (9 зүйл) амьдралтай шувуу давамгайлж байна. Энэ нь тус нутаг бутлаг ургамал зонхилон ургадаг нутаг болох онцлог байдалтай холбоотой юм.

Идэш тэжээлийн байдлаар авч үзвэл:

- Мэрэгч амьтдаар хооллодог: *Buteo hemilasius*, *Aquila nipalensis*, *Falco tinnunculus*, *Athene noctua*;
- Шавжаар хооллодог: *Upupa epops*, *Silvia nana*, *Motacilla alba*, *Apus pacificus*, *Oenanthe oenanthe*, *Oenanthe deserti*, *Oenanthe usabellina*;
- Шавж, ургамлын үрээр хооллодог: *Tadorna ferruginea*, *Columbia livia*, *Pica pica*, *Alauda arvensis*, *Galerida cristata*, *Turdus naumanni*, *Passer montanus*, *Passer domesticus*, *Passer ammodendri*, *Petronia petronia*, *Emberiza pusilla*;
- Үрээр: *Syrnhaptis paradoxus*,
- Гүрвэлээр хооллодог: *Athene noctua*;

- Усны ургамлаар хооллодог: *Anas strepera*;
- Сэгээр хооллодог: *Aegyphus monachus*;
- Элдэв идэштэй: *Milvus migrans*, *Corvus corone*, *Corvus corax* зэрэг зүйл байна.

Шувууны зүйлийн бүрэлдэхүүний бараг гуравны нэг нь (11 зүйл) шавж, ургамлын үрээр хооллож байгаа ба дараа нь дан ганц шавжаар хооллодог (7 зүйл) зүйл орж байна. Эндээс харахад тус нутгийн шувуудын идэш тэжээлд шавж чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

- Шувуудын үүрээ засах газрыг авч үзвэл:
- Нүхэнд: *Tadorna ferruginea*;
- Хад чулуун дээр: *Buteo hemilasius*, *Aquila nipalensis*, *Milvus migrans*, *Falco tinnunculus*, *Aegyphus monachus*, *Athene noctua*, *Upupa epops*, *Apus pacificus*, *Petronia petronia*;
- Нүх, хаданд: *Oenanthe oenanthe*, *Oenanthe deserti*, *Oenanthe usabellina*;
- Бут, хаданд: *Eremophila alpestris*;
- Газарт: *Anas strepera*, *Syrhaptus paradoxus*, *Alauda arvensis*, *Calandrella heleensis*, *Anthus richardi*, *Galerida cristata*, *Turdus naumanni*, *Emberiza pusilla*;
- Бутан дээр: *Sylvia nana*, *Motacilla alba*, *Pica pica*, *Corvus corone*, *Corvus corax*, *Passer ammodendri*;
- Барилга байгууламжинд: *Columbia livia*, *Passer montanus*, *Passer domesticus* үүрээ засч ангаахай, дэгдээхэйгээ бойжуулна.

Дээрх судалгаанаас үзэхэд тус нутгийн хад чулуу, газар, бутан дээр шувууд гол төлөв үүрээ засдаг ба үүнд нам уулс, толгод, бутлаг ургамал шувуудын амьдрах хамгийн чухал биотоп болох нь харагдаж байна.

Баянбүрдийг илэрхийлэгч шувууд болох *Passer montanus*, *Galerida cristata*, *Upupa epops*, *Milvus migrans* энэ нутагт тохиолдох ба баянбүрд, толгод бүхий энэ нутаг нүүдлийн шувуудад уудам цөл нутгийг гатлан өнгөрөхдөө бууж амрах нөхцлийг хангаж өгнө. Тухайлбал, Алтайн өвөр говийн шувуудын бүрэлдэхүүнд ордог Шунгууртан (Podicipediformes), Өрвийтөн (Ciconiiformes), Галуутан (Anseriformes), Тогоруутан (Gruiformes) зэрэг багийн олон зүйл шувуу нүүдлийн үедээ дамжин өнгөрдөг нутгийн нэг юм. Говийн тэгш тал газрыг илэрхийлэгч индикатор шувуудаас *Corvus corax*, *Podoces hendersoni*, *Passer ammodendri*, *Eremophila alpestris*, *Oenanthe deserti*, *Sylvia nana* энэ нутагт тохиолдоно.



Сууршлын хэлбэр болох өвөлжөө бууц, хашаа хороо нь суурин шувуудыг татаж синантроп шувууны аймгийг бий болгодог. Ийм шувуудаас энэ нутагт сохор элээ, тагтаа, хон хэрээ цөөн, оронгийн бор шувуу, хээрийн бор шувуу элбэг тохиолдож байсан ба энэ байдлаар нь ийм бүлэг бүрэлдэх шатандаа байна гэж үзэж болохоор байна.

### Төслийн талбайд хийсэн амьтны аймгийн судалгаа

**Хөхтөн амьтад:** Өмнөговь аймгийн Гурван тэс суман дахь метан хийн хайгуулын талбай болон түүний хавь ойрын нутгаас хаврын улиралд буюу 4-р сарын 3-наас 11-ныг хүртэл нийт 2 багийн, 2 овгийн, 2 зүйл хөхтөн амьтныг нүдээр болон ул мөр үзэн бүртгэж тэмдэглэсэн.

#### Хүснэгт 36. Хөхтөн амьтдын зүйлийн бүртгэл

Зүйлийн монгол нэр	Зүйлийн латин нэр	Болгалийн тоо
<b>Туулайтан баг</b>		
Боролзон туулай	<i>Lepus tolia</i>	1
<b>Туруутан баг</b>		
Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	52


**Хар сүүлт:** Хар сүүлт зээр нь зонхилон дагжуу хөрст, шүүслэг ургамалтай нутагт байрлана. Ихэвчлэн таана-хөмүүлт-үетэнт, заг-бударгант, үетэн-элдэв өвст говийн уулсын бэлийн сайр, садарга, захын жижиг толгод, тэдгээрийн ам хөндийд улирлын аяс, идэш тэжээл, ус ундааны соргогыг дагаж улирлаар нутаг сэлгэн байрладаг байна.







Зураг 72. Төслийн талбайн ойрчим тааралдсан хар сүүлт

Судалгааны талбайд нийт 12 сүргийн 52 бодгаль үзэж тэмдэглэж үүнээс 28.3% нь эр, 71.7% нь эм байна. Сүргийн харьцаа 1:2,5 байгаа нь нэг эр амьтанд 2 эм амьтан ноогдож байгаан сүргийн бүтэц хэвийн байна.



Хар сүүлт зээрийг 1953 онд агнахыг хориглон дархан цаазат ховор амьтны тоонд оруулсан байдаг. Гэхдээ гадаадын анчид тусгай зөвшөөрлөөр агнаж болдог. Засгийн газраас агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 450 ам.доллараар тогтоосон (MNE, 2005). Хар сүүлтий тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан. Алтайн өвөр говьд Булган голоос зүүн тийш, Алтайн ар говьд Увс нуураас зүүн тийш, Их нууруудын хотгор, нуурын хөндийг дагаж, Өмнийн говь, Дорнын говь, зүүн зах нь Сүхбаатар аймгийн баруун нутаг хүртэл тархсан байна.



Зураг 73. Хар сүүлт тархалтын зураглал

**Боролзон туулай:** Бор туулай нь голын хөндий, намхан уулсын энгэр, бэл, асга хадат өндөр уул, тэр орчмын жижиг гүвээ, толгод, дов сондуулт хотос, бут, дэрстэй хөндий, голын хэсэг хэсэгхэн төгөл, ойн доод зах, тариалангийн талбай орчимд байрлана. Өвлийн улиралд цас багатай газар дагаж голын хөндий, уулын бэл, хормой, жижиг төгөл болон хад асгатай уулын энгэрт нөмөрлөн байрлана. Зун ийм орчинд байх боловч ойн дээд зах, таг, уулын ар, өврийн гуу жалганд элбэг тохиолддог. Тал хээрт өвөл бөөрөгт толгод хотсын энгэр бэл, дэрс сондуулт хөндийд идэшлэнэ. Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэл хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Бор туулайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагджээ.

**Шувууд:** Өмнөговь аймгийн Гурван тэс суман дахь метан хийн талбайд түүний хавь ойрын нутгаас хаварын улиралд буюу 4-р сарын 7-наас 11-ныг хүртэл нийт 3 багийн, 5 овгийн, 8 зүйл шувуудыг нүдээр үзэн бүртгэж тэмдэглэсэн.



Зураг 74. Төслийн талбайн ойрчим тааралдсан шувууд

Хүснэгт 37. Шувууны бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр

№	Зүйлийн нэр	Оршин амьдрах хэлбэр		
		Суурин	Тохюлдлын	Нүүдлийн
<b>Шонхортон-Falconiformes</b>				
11	Сохор элээ- <i>Milvus migrans</i>			+
<b>Тагтаатан-Columbiformes</b>				
22	Говийн ногтруу- <i>Syrhaptus paradoxus</i>	+		
<b>Боршувуутан-Passeriformes</b>				
33	Дэрсний жиргэмэл- <i>Calandrella cheleensis</i>			+
44	Шоорон эвэртболжмор- <i>Eremophila aplestris</i>	+		
55	Монгол хулан жороо- <i>Podoces hendersoni</i>			+
66	Хар хэрээ- <i>Corvus corone</i>	+		
77	Эвэрт болжмор- <i>Galerida cristata</i>			+
88	Хээрийн бор шувуу- <i>Passer montanus</i>	+		
	Бүгд: 8 зүйл	4		4

Шувуудаас 4 зүйл суурин амьдралтай, 4 зүйл нүүдэллэн ирж өндөглөн зусдаг байна.

**Сохор элээ:** Хадны дэвцэг, модон дээр үүр засч 3-5 өндөг гаргана. Сэг, хоолны хаягдал, жижиг амьтан, загасаар хооллоно. Суурин газар тааралддаг, хүнд ойромсог шувуу. Өндөглөдөг, нүүдлийн шувуу.

**Хар хэрээ:** Модны дунд хавьд үүр засч, 1-2 хоногийн дараалалтайгаар бор толботой, 4-6 ширхэг ногоовтор өнгөтэй өндөг гаргана. Ойт хээр, мод буттай газраар тархсан. Элдэв идэштэй. Суурин ба ойр зуур нүүдэг шувуу.

**Говийн ногтруу:** Газар хонхойлон үүрлэж 2-3 өндөг гаргана. Хуурай хээр, говь, цөлд тархана. Үетэн, бусад ургамлын үрээр хооллоно. Суурин шувуу.

**Согсоот божирго:** Газар үүр засч, 3-6 өндөг гаргана. Хээр тал, хээржсэн цөл, говиор амьдрана. Үр, шавьжаар хооллоно.

**Шоорон эвэрт болжмор:** Бут сөөг, хадны нөмөрт үүр засч, 3-5 өндөг гаргана. Говь, хээр, уулын хээр, модгүй уулсаар амьдрана. Шавьж, үрээр хооллоно. Суурин, ойр зуур шилжин нүүдэг.

**Монгол хуланжороо:** Жижиг чулуурхаг, хужир мараа бүхий заг, сухай, сөөг ургамалтай элсэрхэг цөл, баянбүрд, уул толгодын сайртай нутагт амьдарна. Суурин шувуу. Шавж, ургамлын үр, гүрвэлээр хооллоно.

**Хээрийн бор шувуу:** Суурин газар, тариалангийн талбай, ойн зах, голын хөндийд амьдарна. Залаат ургамал болон бусад ургамлын үр, эрвээхэйгээр хооллоно.

**Дэрсний жиргэмэл:** Хээр тал, дэрстэй хотгоруудаар амьдарна. Ойр зуур нүүдэлдэг суурин шувуу. Ургатлын үр, шавжаар хооллоно.

**Хамгаалагдсан байдал:** Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES-ийн) ийн 2-р хавсралтанд сохор элээ бүртгэгдсэн байхад, Нүүдлийн амьтныг хамгаалах олон улсын конвенц CMS-д мөн сохор элээ, Монгол Улсын Улаан номд хулан жороо тус тус бүртгэлтэй бөгөөд эдгээр нь монгол Улсын болон олон улсын хууль тогтоомжоор агнах, идээшил орон байрыг нь сүйтгэх байршил нутгаас нь шахан зайлуулахад хориотой амьтад юм. Дээрх 2 зүйл шувуу нь зөвхөн монгол оронд төдийгүй дэлхий нийтийн хэмжээнд ховордсон нь хамгаалалтаас хархад тодорхой байгаа юм. Иймээс дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа дээрх зүйл шувуудыг бусдаас онцгойд үзэж хамгаалах шаардлагатай нь тодорхой байна.



Хүснэгт 38. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын нэгжийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал	
1		2		3		4		5	
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>									
1	Агаарын чанарын шинжилгээ хийлгэж байх	5 цооног бүр дээр	2022 оны 3, 6 сард	2	58,000	580,000	NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub>	Агаарын чанар. MNS 4585:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ 17.2.3.16-88 Тоосны Хэмжээг тодорхойлох Жингийн арга. MNS 4048:88	
2	Тээврийн хэрэгсэлийн хаягдал утааны хяналт шинжилгээ	2 машин	2022 оны 3, 6 сард	2	10,000	40,000			
<b>2. ГАДАРТЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР</b>									
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Малчдын гар болон өрөмдмөл нийт 7 худгийн усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн.	2022 оны 4, 7 сард	2	33,000	462,000	Кальци, Магний, Карбонат, Хлорид, Гидрокарбонат, Нитрит, Төмөр, Сульфат, Натри+Кали, Хуурай үлдэгдэл, рН Цахилгаан дамжуулах чанар, Ерөнхий хатуулаг	MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны Бохирдуулагч одисын зөвшөөрөгдөх дээд	
2	Гадаргын болон газрын доорх усны бохирдлын	Бага овоо багийн төвийн гүний худаг	2022 оны 4, 7 сард	2	74,900	149,800	Манган, Никель Зэс, Кадми, Кобальт, Хар тугалга, Цайр, Хром, Төмөр, Бисмут,		

хяналт хийх	Хөнгөнцагаан Бари,	хэмжээ						
Ундны усны бохирдолын хяналт хийх	Гал тогоо	75,800						
<b>3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ	Хайгуулын 5 цооног орчим, Ажилчдын кемпийн хашаанд	2022 оны 4, 7 сард	2	37,900	300,000	Агрохими, Механик бүрэлдэхүүн	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, MNS 5915 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал, MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,
2	Хөрсний бохирдлын шинжилгээ	Хайгуулын 5 цооног орчим, Ажилчдын кемпийн хашаанд	2022 оны 5, 8 сард	2	25,000	300,000	Cd/кадми, Pb/харгугага, Cr/хром, Zn /цайр/, Cu /зэс/, Ni /никель/	
<b>Хяналт мониторингийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн зардал</b>			<b>1,907,600</b>					

## АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тэлмэн Ресурс” ХХК нь мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, зааварчилгаануудад хамруулсан. Үүнд:

- Түргэн тусламжийн амилуулах нийгэмлэгийн “Яаралтай тусламжийн цогц менежмент” гэрчилгээ олгох сургалтанд 11 ажилтан хамрагдаж амжилттай суралцсан.
- “Safety Training and Consulting Service” LLC Нийт Ажилтны ХАБЭА-н СЕРТИФИКАТ олгох сургалтанд ажилтнуудаа хамруулсан.
- Хайгуулын талбайд ажиллахаар очсон нийт ажилтнуудаа “Өсөх Зоос” ХХК, “МАК” ХХК, “СГС” ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын шинэ ажилтаны сургалтанд хамруулж ажилд гаргасан.
- Төслийн талбайд жолоо барих ажилтнуудаа “Өсөх Зоос” ХХК, “МАК” ХХК, “СГС” ХХК-ийн жолооны эрх олгох сургалтанд хамруулж шалгалт өгч “Уурхайн бүсэд жолоо барих эрхийн үнэмлэх” авч ажилд гаргасан.



Зураг 75. “Овоот” жолооны үнэмлэх

Эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгааг хийхдээ “Бриллианс клиник” ХХК-тай 2022 оны 02 сарын 18-ны өдөр “ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ” гэрээг байгуулан Бриллиант эмнэлэгт үзлэг оношилгоонд хамруулсан. / Хавсралт 29, а /

Хүснэгт 39. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээний биелэлт	Урьдчилан тооцсон төсөв, зардал	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2022 он					
			I	II	III	IV		
1	Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулан ажилласан	Үйл ажиллагааны зардал	+	+	+	Хариуцсан мэргэжилтэн	Байгаль орчны мэргэжилтэн сонгон шалгаруулалт хийж БОМэргэжилтэнг ажлын байранд авсан.	
2	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, зааварчилгаанд суулгаж хэвшсэн.	Үйл ажиллагааны зардал		+	+	Мэргэжлийн байгууллага “Тэлмэн ресурс” ХХК	Ажилчдын байгаль орчны Боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах	
6	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгааг “Бриллианс клиник” ХХК-тай гэрээ байгуулан Бриллиант эмнэлэгт үзлэг оношилгоонд хамруулсан.	Догоод төлөвлөлтөөр		+	+	Мэргэжлийн Байгууллага “Тэлмэн ресурс” ХХК	Ажилчдыг үйлдвэрийн болон бусад гаралтай өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх,	
<b>Ийнхүү</b>								
Үйл ажиллагааны зардал тусгагдан хэрэгжүүлгийг хангасан								

## АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тэлмэн Ресурс” ХХК нь 2022 онд Дадлагажигч оюутан, мэргэжил бүхэн сайхан, ахмадуудын хүндэтгэлийн хүлээн авалт, боловсролын байгууллагын багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэх, мөн Монгол улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдаж нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан дэмжлэг үзүүлэн, ахмадуудын хүндэтгэлийн хүлээн авалт хийх зэргээр нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилласан.

Гурвантэс сумын ЗДТГ-тай хамтран Гурвантэс сумын оюутан залуучуудын уулзалтыг 2022 оны 10 сарын 22-ны өдөр Нийслэл худалдааны төвийн Н лаунжд хамтран зохион байгуулж компанийн зүгээс Дадлагажигч оюутан (Internship) Хөтөлбөрийг танилцуулсан.



Зураг 76. Дадлагажигч оюутан (Internship) Хөтөлбөрийг танилцуулж буй байдал



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Ерөнхий Боловсролын Сургуультай хамтран тус сургуулийн 9-р ангийн 3 бүлгийн нийт 80 гаруй сурагчдад 2022 оны 5 дугаар сарны 10-ны өдөр "Мэргэжил Бүхэн сайхан" сэдэвт мэргэжил сурталчлах өдрийг амжилттай зохион явуулсан.



Зураг 77. "Мэргэжил Бүхэн сайхан" сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөг



Зураг 78. Ахмадуудын хүндэтгэлийн хүлээн авалт



Зураг 79. Гурвантэс сумын багийн иргэдийн хуралд хагас жилийн тайлан танилцуулав / 2022.06 сар /



Хүснэгт 40. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохих байгуулах хугацааны тов	Харуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохих байгуулах газар
1	<p>“Тэлмэн Ресурс” ХХК-ийн холбогдох удирдлага, БОХАБ-ын нэгж</p> <p>Орон нутгийн удирдлага, олон нийтийг хамарсан хэд хэдэн ажлыг зохион явуулсан</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дадагдажигч оюутан (Internship)</li> <li>• Хөтөлбөрийг танилцуулсан,</li> <li>• "Мэргэжил Бүхэн сайхан" сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөг,</li> <li>• Ахмадуудын хүндэтгэлийн хүлээн авалт,</li> <li>• Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн дэмжлэг,</li> <li>• Багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлсэн.</li> </ul>	Цахим тайлан	БОХМТ, БОХМГБТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	БО-ны мэргэжилтэн	Дотоод төлөвлөлтөөр	“Тэлмэн Ресурс” ХХК-ийн байр
2	<p>Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн дэмжлэг,</p> <p>Багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлсэн.</p>	Мэдээллийг илтгэл байдлаар танилцуулсан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр	Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	Төслийн ерөнхий менежер	Үйл ажиллагааны зардалд орсон	Нутгийн удирдлагын ордон
3	<p>Хайгуулын дооног байрлах орчны оршин суучиддад уулзах уулзалтыг ОХШХ хүрээнд 2 удаа зохион явуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ц.Осор,</li> <li>• Д.Мөнхсайхан,</li> <li>• Н.Отгонбаяр,</li> <li>• Н.Баярсайхан,</li> <li>• Д.Төрхүү,</li> <li>• Д.Мөнхсайхан,</li> <li>• Н.Мөнхбаяр айгуулаас усны дээж авч шинжилгээний хариуг хүлээлгэн өгсөн.</li> </ul>	Усны шинжилгээний хариуг хэвлэмэл байдлаар танилцуулсан	Уялдны усны чанарын шинжилгээ	Жил бүрийн 12 сарын 25-ны дотор	БО-ны мэргэжилтэн	ОХШХ-ийн зардалд орсон	Ажилчдын кемп, багийн төв

4	<p>Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-овоо багийн ИНХ, сумын ИНТХураалд оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бага-овоо багийн ИНХ 2022 оны 06 сард Хагас жилийн ажлын тайлан танилцуулсан.</li> <li>Гурвантэс сумын ИНТХураалд 2022 оны 09 сард тус тус оролцсон.</li> </ul>	Мэдээллийг илтгэл байдлаар танилцуулсан	Ундны усны чанарын шинжилгээ	Жил бүрийн 12 сарын 25-ны дотор	БО-ны мэргэжилтэн	ОХШХ-ийн зардалд орсон	Ажилчдын кемп, багийн төв
5	<p>Өрхийн уулзалтыг тогтмол хийж Нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилладаг байсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ц.Осор: Малын гэжээл ногоон ургамал хамгаалах хашаа хийсэн,</li> <li>Д.Мөнхсайхан: 100ш хайлаас молдыг мод үржүүлгийн хашаанд нь тарьж ургуулахад хамтран ажиллаж хүлээлгэн өгсөн.</li> </ul>	Уулзалт хэлбэрээр	Танин мэдэхүйн мэдээлэлээр хангах	Улирал бүр	БО-ны мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардалд орсон	Өрхүүдээр
<b>Нийт</b>							
Үйл ажиллагааны зардал, ОХШХ-ийн зардалд орсон зардал							

## АРВАН ГУРАВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРДАЛ

Төслийн үйл ажиллагаанд БОМТ-г хэрэгжүүлэхэд 2022онд нийт 19,594,500 мянган төгрөгийн зардал төлөвлөсөн ч 20,055,500 төгрөг зарцуулсан байна.

### Хүснэгт 41. БОМТ-г хэрэгжүүлсэн нийт зардал

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал	Нийт дүнд эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	825,000	4.4
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн зардал	6,978,600	37.8
3	Түүх соёлын өвийг хамгаалах	0	0
4	Осол эрсдэл, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,551,300	19.2
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	670,000	3.6
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал	4,523,000	24.5
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн зардал	1,907,600	10.3
8	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	Үйл ажиллагааны зардалд тусгагдан хэрэгжилтийг хангасан	
9	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт		
<b>Нийт зардал</b>		<b>18,455,500</b>	<b>99.9</b>